УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2021 оны 11 сарын 30 өдөр Дугаар А/322 Улаанбаатар хот

"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах тухай

Хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 4 дүгээр хэсгийн 4.6.11-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсад худалдаа, хоршоо, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд "Монгол үндэсний хоол хэрэглээний уламжлал, орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг өргөн олонд сурталчлах, тогооч нарын мэргэжил, мэргэшлийн ур чадвар, бүтээлч хандлагыг дээшлүүлэх, тогооч нарын харилцан туршлага солилцуулах зорилго бүхий "Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдааныг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулахыг Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэс (Т.Золжаргал)-т үүрэг болгосугай.

1. "Хотын аварга тогооч" ажил мэргэжлийн уралдааны бэлтгэл ажлын төлөвлөгөөг 1 дүгээр, "Хотын аварга тогооч" шалгаруулах удирдамжийг 2 дугаар, зохион байгуулахад шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар ёсоор тус тус батлсугай.

2. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад удирдамжийг хүргүүлж, мэргэжлийн тогооч нарыг оролцуулахыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт, "Монголын Мастер тогоочдын холбоо" ТББ (Д.Буяндэлгэр)-д, уралдааныг үр дүнтэй зохион байгуулж, тайланг фото зураг, илтгэх хуудсаар 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дотор танилцуулахыг Хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэс (Т.Золжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 2.870.000 /хоёр сая найман зуун далан мянга/ төгрөгийг бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Цэрмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/264 дүгээр тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНБОЛД

C:\Users\Gantuya\Desktop\ҮЖ 12\doc 2021\тушаал 2.docx

1110301000

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 11 дүгээр сарын 30 өдрийн
А/322 тушаалын 1 дүгээр хавсралт

ХУДАЛДАА, ХОРШОО, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙГ УГТСАН АЖЛЫН ХҮРЭЭНД "ХОТЫН АВАРГА ТОГООЧ " ШАЛГАРУУЛАХ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНЫ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Монгол улсад худалдаа, хоршоо, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд монгол үндэсний хоол хэрэглээний уламжлал, орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг өргөн олонд сурталчлах, шинэ арга хэлбэрээр баяжуулах, тогооч нарын мэргэжил, мэргэшлийн ур чадвар, бүтээлч хандлагыг дээшлүүлэх, хоол үйлдвэрлэлийн уламжлалт болон орчин үеийн шинэ технологийг нэвтрүүлэх, хоол хийх урлагийг хөгжүүлэх, тогооч нар харилцан туршлага солилцоход оршино.

Оролцогч: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын мэргэжлийн тогооч

Хаана: Хангарьд ордны 15 давхарын Зоогийн газарт

Тэмцээний бэлтгэл ажил: 2021.11.29-2021.12.09-ний өдрүүдэд

Уралдаан болох хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр /08:00-17:00 цагт/

№	Зохион байгуулах ажил	Хугацаа	Хариуцах байгууллага/албан хаагч		Хамтран зохион байгуулагч
1.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдааны бэлтгэл ажлын төлөвлөгөө, зардлын төсөв гаргах.	29/XI	УБЗАА ХҮХҮХ	Мэргэжилтэн Я.Бадмаа	Монголын Мастер тогоочдын холбоо ТББ
2.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдааны зардлын тушаал, шийдвэр гаргуулах, гүйцэтгэлийн тайлан санхүүд гаргаж өгөх.	29/XI-14/XII	УБЗАА ХҮХҮХ	Мэргэжилтэн Я.Бадмаа	Монголын Мастер тогоочдын холбоо ТББ

3.	Батлагдсан удирдамжийг арга хэмжээнд оролцогчдод тараах холбогдох газруудад хүргүүлэх.	30/XI	УБЗАА ХҮХҮХ ММТХ	Мэргэжилтэн Я.Бадмаа ММТХ-ны ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	ДЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн нар
4.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн ур чадварын тэмцээнд оролцох тогоочдын бүртгэлийг хийх.	02/XII-09/XII	ДЗДТГХҮХ ҮХ ММТХ	ММТХ-ны ерөнхийлөгч Д.Буяндэлгэр ДЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн нар	
5.	Оролцогчдын нэрсийг нэгтгэж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд ирүүлэх.	09/XII	ММТХ	ММТХ-ны ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	ДЗДТГ
6.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан болох ажлын байр /заал/ бэлтгэх.	09/XII	УБЗАА ХҮХҮХ ЧД ЗДТГ	Мэргэжилтэн Я.Бадмаа ЧД-ийн ХХҮХ-ийн мэргэжилтэн С.Намуунзаяа	Монголын Мастер тогоочдын холбоо ТББ
7.	"Хотын аварга Тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаанд оролцогчдод 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 16:00 цагт техникийн зөвлөгөө өгөх, мандат олгох. /Оролцогчдыг бүртгэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах/	09/XII	ММТХ	Монголын Мастер тогоочдын холбоо ТББ –ын Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр /Ажлын хэсэг/	ХУД-ийн ЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Г.Тэргэл
8.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан тэмцээний хөтөлбөр гаргах.	08/XII	УБЗАА ХҮХҮХ ММТХ	Мэргэжилтэн Я.Бадмаа ММТХ-ны ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	
9.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаанд шалгарсан тогооч нарыг шагнах өргөмжлөлийн загвар бэлтгэх, хэвлүүлэх. Шагнал гардуулах ажиллагааг хариуцах • Өргөмжлөл - 4 ш • Тусгай байрын шагнал -3 ш	01-03, 08/XII	СБД ЗДТГ	СБД-ийн ЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Н.Оюунчимэг	УБЗАА Мэргэжилтэн Я.Бадмаа
10.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдааны тэмцээний шүүгчдийг томилох, ажлын зардлыг хариуцах.	09/XII	ММТХ	Монголын Мастер тогоочдын холбоо ТББ-Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	Мэргэжилтэн Я.Бадмаа ДЗДТГ

11.	Оролцогчдын түүхий эд материалыг бэлтгэх, хувиарлах	09/XII	ММТХ	Монголын Мастер тогоочдын холбоо ТББ-Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	Оролцогчид
12.	Ажлын байрны зураглал гаргах, оролцогчдыг хувиарлах	09/XII	ММТХ	Монголын Мастер тогоочдын холбоо ТББ-Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	БЗД-ийн ЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн н.Ганцэцэг
13.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдааны анонс, баннерийн эх бэлтгэж хэвлүүлэх.	02/XII	БГД-ийн ЗДТГ	ХХҮХ-ийн дарга Б.Бат-Өлзий	УБЗАА ХҮХҮХ Мэргэжилтэн Я.Бадмаа
14.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдааны арга хэмжээнд хөгжим, микрофон, дэлгэц, проектор бэлтгэж байрлуулах, тэмцээний үеийн бэлэн байдлыг хангах	09/XII	ХУД-ийн ЗДТГ	Хан-Уул дүүргийн ХХҮХ-ийн дарга Л.Саруултуяа	ХУД-ийн ЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Г.Тэргэл
15.	Тэмцээний нээлтийн хэлэх үг бэлтгэх	06/XII	УБЗАА ХҮХҮХ ММТХ	Мэргэжилтэн Я.Бадмаа ММТХ-ны Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	
16.	Худалдааны 100 жилийн ойн медиалаар шагнах хүмүүсийн нэрсийг гаргах, гардуулах.	09/XII	УБЗАА	Мэргэжилтэн Я.Бадмаа ММТХ-ны Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	БЗД-ийн ЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн н.Ганцэцэг
17.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн ур чадварын тэмцээний зураг авах, видео бичлэг хийх.	10/XII	ММТХ	ММТХ-ны Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	УБЗАА Э.Хишигбуян
18.	"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн ур чадварын тэмцээний үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, зураг авах.	06/XII-10/XII	УБЗАА ЗСУХ	Э.Хишигбуян	Хэвлэл мэдээлэл

19.	Уралдаанд оролцогчдын хоолны үлдэгдэл хог хаягдлыг хийх зориулалтын саваар хангаж, зөөверлөх асуудлыг шийдвэрлэх.	09/XII	УБЗАА ХХУЗХ	Ахлах мэргэжилтэн Т.Энх-Амгалан	ННҮГ, оролцогчид
20.	Шагнал гардуулах ажиллагаа	10/XII	УБЗАА ММТХ	Мэргэжилтэн Я.Бадмаа ММТХ-ны Ерөнхийлөгч Д.Буяндэлгэр	СБД-ийн ЗДТГ-ын хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Н.Оюунчимэг

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 11 дүгээр сарын 30 өдрийн
А/322 тушаалын 2 дугаар хавсралт

ХУДАЛДАА, ХОРШОО, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙГ УГТСАН АЖЛЫН ХҮРЭЭНД "ХОТЫН АВАРГА ТОГООЧ " ШАЛГАРУУЛАХ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зорилго: Монгол хоол хэрэглээний уламжлал, орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг өргөн олонд сурталчлах, сэргээн хөгжүүлэх, шинэ арга хэлбэрээр баяжуулах, тогооч нар, ялангуяа залуу тогооч нарын мэргэжил, мэргэшлийн ур чадвар, бүтээлч хандлагыг дээшлүүлэх, хэрэглэгчдийн үйлчилгээний өндөр түвшинг хөхүүлэн дэмжих, хоол үйлдвэрлэлийн уламжлалт болон орчин үеийн технологийг оновчтой болгож хоол хүнсний шинэ хэрэглээг бий болгох, хоол хийх урлагийг хөгжүүлэх, тогооч нар харилцан туршлага солилцоход оршино.

Хамрах хүрээ: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ /ресторан, баар, кафе, цайны газар, эмнэлэг, цэцэрлэг, сургууль, үйлдвэрийн дэргэдэх цайны газар/-т ажиллаж буй олон улс, улсын аварга тогооч шалгаруулах уралдаанд оролцож байгаагүй тогооч, хоол үйлдвэрлэгч нар оролцоно.

Ерөнхий зохион байгуулагч:
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
- Монголын мастер тогоочдын холбоо
- Монголын ахлах тогоочийн академи

Хамтран зохион байгуулагч:
- Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар
- 9 дүүргийн Засаг даргын тамгын газрын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс
- Мэргэжлийн холбоод
- Шүүгчид

"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаанд оролцох төрлийн тайлбар:

1. **Орчин үеийн монгол хоол хийх:**

Монгол хоолны хэв маягийг тусгасан, орчин үеийн дэвшилтэт шинэлэг шинж чанартай, бүтээгдэхүүний зохицолдолгоог хангасан монгол үндэсний хоолыг зохион байгуулагч талаас бэлтгэсэн хүнсний материалыг ашиглан 1 төрлийн хоолыг 2 хүнд олгогдох хэмжээгээр заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

- Анхны боловсруулалт, дулааны боловсруулалт, таваглалт зэргийг 60 минутанд багтааж ажилбарыг гүйцэтгэнэ.
- Оролцогч нь хоолны чимэглэл хийх хүнсний материал, хоолонд амт оруулагч зэргийг өөрийн сонголтоор авч ирж болно.
- Хоол таваглах хэрэгслийг өөрийн сонголтоор авч ирж болно.

2. **Гэрийн даалгаварт:**

Оролцогч нар шинэлэг Монгол үндэстэний хоолны уламжлалт чиг хандлагыг харуулсан орчин үеийн чиг хандлагатай өглөөний цай, зоог идээг хамтатган өөрсдийн сонголтоор хийж ирнэ. /Уламжлалт идээ ундааны онцлогыг харуулсан хоолны эдлэл хэрэгсэл орчин зэргийг бүрдүүлж болно /.Зохион байгуулагч талаас бэлтгэсэн 60 см * 80 см харьцаатай ширээн дээр байршуулна. Уралдааны дүнд хамаарагдана.

3. **Онолын шалгалт:**

Оролцогч тогооч нараас 10 асуулттай мэргэжилийн онолын шалгалт авна. Мөн уралдааны дүнд хамаарагдана.

Нийт 100 оноогоор дүгнэнэ. Гэрийн даалгавар 30 оноо, Онол 10 оноо, Үндсэн ажилбарын үнэлгээ 60 оноо.

Шагнал урамшуулал:

1-р байр 1 алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал /500,000 төгрөг/
2-р байр 1 мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал /400,000 төгрөг/
3-р байр 2 тус бүр хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал /300,000 төгрөг/
Тусгай байр 3 тус бүр өргөмжлөл, мөнгөн шагнал /150,000 төгрөг/

Зохион байгуулагч талаас хүлээх үүрэг:
- Тэмцээнд оролцогчдыг бүртгэх, техникийн зөвлөгөө хийх, мандат олгох,
- Оролцогчдыг нийтэд танилцуулах,
- Ажлын байр, бэлтгэлийн ширээ, хоол олгох ширээ зэргээр хангах,
- Эрүүл ахуй, халдвар хамгаалал, ажлын байрны аюулгүй байдлыг хангах /хуурай, нойтон, салфетка, хог хаягдлын сав г.м/,
- Оролцогчдод шаардлагатай тохиолдолд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх,
- Шүүгчдийн үнэлгээг нийтэд харагдахуйц байдлаар байрлуулах /хэвлэл, проектор, цахим хуудас гэх мэт/

Уралдаанд оролцогч тогоочийн хүлээх үүрэг:
- Тогооч удирдамжинд заасны дагуу хугацаандаа бүртгүүлж техникийн зөвлөгөөнд өөрийн биеэр хамрагдана.
  Оролцогч дараах материалыг бүрэн авч ирж бүртгүүлнэ. Үүнд:
  - 3х4 хэмжээтэй зураг 2 хувь
  - Мэргэжлийн үнэмлэхний хуулбар /мэргэжлийн ур чадварын чадамжын гэрчилгээ/-г хавсаргах
  - Ажлын газрын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэхтэй ирэх
  - Дархлаажуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу халдварын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсан, Коронавируст (Ковид-19) халдвараар өвчилж эдгэсэн тухай эрүүл мэндийн байгууллагаас магадлагаа авсан тогоочийг оролцуулах;
- Техникийн зөвлөгөөний хурлыг цахимаар явуулах

Оролцогчид дараах зарчмаар уралдаанд оролцоно. Үүнд:
- Заасан хугацаанд багтаж ажлын байраа бэлтгэсэн байх
- Хоол хийх цэвэр усаа авчрах,
- Оролцогчид нэмэлт шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн авч ирэх
- Оролцогч нь ХАБЭА–н шаардлагыг өөрийн зүгээс хангах
- Өөрсдийн сав хэрэгсэл, багаж хэрэгсэлийг авч ирэх
- Оролцогч нь хийх хоолныхоо технологийн картыг бичиж авч ирэх

Хаана болох:

"Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 08:00 цагт эхлэнэ. Тэмцээн болох газрыг техникийн зөвлөгөөн дээр мэдэгдэнэ.

Техникийн зөвлөгөөн:

2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 16:00 цагт Монголын мастер тогоочдын холбооны танхимаас онлайнаар явуулна.

Уралдаанд оролцогчдын материал хүлээн авах:

2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 15.00 цаг хүртэл Монголын мастер тогоочдын холбоо хүлээн авна. Бүртгэл хийлгэхэд холбоо барих утас: 99122158, 99299697,99026790

Жич. Хугацаа хоцорсон тохиолдолд оролцогчдын материал хүлээн авахгүй болно.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 11 дүгээр сарын 10 өдрийн
А/322 тушаалын 2 дугаар хавсралт

Худалдаа, хоршоо, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ой угтсан ажлын хүрээнд "Хотын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдааны зардлын төсөв

№	Зохион байгуулагдах үйл ажиллагаа	Нэгж	Тоо, ширхэг	Нэгж үнэ мян/төгрөг	Нийт дүн мян/төгрөг
1.	Шагнал урамшуулал	Мөнгөн шагнал	1 байр 1	500.0 төг	500.0 төг
2.			2 байр 1	400.0 төг	400.0 төг
3.			3 байр 2	300.0 төг	600.0 төг
4.	Тусгай байр	Мөнгөн шагнал	Тусгай байр 3	150.0 төг	450.0 төг
5.	Өргөмжлөл хэвлүүлэх	ш	4	120.0 төг	480.0 төг
6.	Тусгай байрын шагнал /өргөмжлөл/	ш	3	40.0 төг	120.0 төг
7.	Арга хэмжээний анонс, баннер	ш	2	60.0 төг	120.0 төг
8.	Ажлын байрны цэвэрлэгээ /ариутгалын бодис, оролцогчдын гар халдаргүйжүүлэх спиртэн суурьтай уусмал, хуурай нойтон цаасан алчуур/	ш	100	2.0 төг	200.0 төг
9.	Байр талбайн халдваргүйжүүлэлт 1.00 цаг тутам	удаа	6		
10.	Дүн				2.870.0төгрөг